

**ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БОЛОН ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООДЫН  
ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр, Пүрэв гараг**

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

**Хуралдааны товч тэмдэглэл:** 1-3

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 4-13

---

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоолд бүхэлд нь тавьсан хоригийг Улсын Их Хурал хүлээж авсантай холбогдуулан хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх дэгийн тухай хуулийн төсөл 4-13

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Ёс зүй, дэгийн болон Хууль зүйн байнгын хороодын  
11 дүгээр сарын 28-ны өдөр /Пүрэв гараг/-ийн  
хамтарсан уралдааны товч тэмдэглэл**

Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 34 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 07 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баасанжаргал, Б.Пүрэвдорж, Д.Рэгдэл, П.Сайнзориг, Г.Уянгахишиг, Б.Энхбаяр, Д.Энхтуяа, С.Эрдэнэболд;

Чөлөөтэй: Н.Алтанхуяа, Э.Бат-Амгалан, Х.Баттулга, Б.Жавхлан, Л.Мөнхбаатар;

Тасалсан: Х.Тэмүүжин.

**Нэг.Монгол Улсын Ерөнхийлөгчийн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоолд бүхэлд нь тавьсан хоригийг Улсын Их Хурал хүлээж авсантай холбогдуулан хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх дэгийн тухай хуулийн төсөл**

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Хуулийн төслийг Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Л.Соронзонболд нарын тавьсан асуултад Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Д.Цогтбаатар, О.Номинчимэг, Б.Баярбаатар нар үг хэлэв.

*Монгол Улсын Ерөнхийлөгчийн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоолд бүхэлд нь тавьсан хоригийг Улсын Их Хурал хүлээж авсантай холбогдуулан хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх дэгийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Б.Баярбаатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан, Төслийн “2.8.Төслийн талаар төрийн аудитын байгууллага болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг гаргуулж болно.” гэсэн заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	3
Татгалзсан:	17
Бүгд:	20

15.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболдын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.7.3 дахь заалт шинээр нэмэх:

“3.7.3.төсөлд зардлын зүйл шинээр нэмэхгүй байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	5
Татгалзсан:	15
Бүгд:	20

25.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

**Б.Баярбаатар:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоолд бүхэлд нь тавьсан хоригийг Улсын Их Хурал хүлээж авсантай холбогдуулан хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх дэгийн тухай хуулийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	14
Татгалзсан:	6
Бүгд:	20

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хороодын хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 28 минут үргэлжилж, 34 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 58.8 хувийн ирцтэйгээр 14 цаг 35 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:  
ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Б.БАЯРБААТАР

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим  
14 цаг 07 минут.

### ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БОЛОН ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Б.Баярбаатар:** Та бүхэндээ өдрийн мэндийг хүргэе. Яваандаа ороод ирэх байлгүй дээ. Хурлаа эхлээд танилцуулгаа хийж л байя л даа. Болохгүй юм уу? Хурлын ирцийг танилцуулна. Хууль зүй болон Ёс зүй, дэгийн байнгын хорооны хамтарсан хуралдаан 18 гишүүн ирснээр хурлын ирц хүрчээ. Хурал нээснийг мэдэгдье.

Жуковын Алдаржавхлан гишүүн ирсэн байна, Аюушийн Ариунзаяа гишүүн ирсэн байна, Жамбын Батсуурь гишүүн ирсэн байна, Баярмагнайн Баярбаатар байна, Дуламын Бум-Очир гишүүн ирсэн байна, Даваасамбуугийн Ганмаа гишүүн ирсэн байна, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн ирсэн байна, Батжаргалын Заяабал гишүүн ирсэн байна, Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн ирсэн байна, Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн ирсэн байна, Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн байна, Салдангийн Одонтуяа гишүүн ирсэн байна, Ухнаагийн Отгонбаяр гишүүн ирсэн байна, Ганбатын Очирбат гишүүн ирсэн байна, Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн байна, Бадарчийн Хэрлэн гишүүн ирсэн байна, Дамдины Цогтбаатар гишүүн ирсэн байна, Даваагийн Цогтбаатар гишүүн ирсэн байна. Байнгын хорооны гишүүдийн олонх цугласан байна.

Хэлэлцэх асуудлаа та бүхэнд танилцуулъя. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоолд бүхэлд нь тавьсан хоригийг Улсын Их Хурал хүлээж авсантай холбогдуулан хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх Дэгийн тухай хуулийн төслийг хэлэлцэж, хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Байхгүй байгаа бол хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай болон хамт баталсан хууль, тогтоолд бүхэлд нь тавьсан хоригийг Улсын Их Хурал хүлээж авсантай холбогдуулан хууль, тогтоолын төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх Дэгийн тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье. Өчигдөр Байнгын хорооны, хамтарсан Байнгын хорооны шийдвэр гарч, 9 гишүүнтэй санал боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсэг Хууль зүйн байнгын хорооноос 5 гишүүн, Ёс зүй, дэгийн байнгын хорооноос 4 гишүүн орж ажлын хэсэгт ажилласан. Дээр нь Тамгын газар, холбогдох удирдах албан тушаалтнууд, зөвлөхүүд орж ажилласан байгаа. Нийт ажлын хэсгийн гишүүддээ бас талархал илэрхийлье.

Дээр нь Хууль зүйн байнгын хороондоо албан ёсоор талархал илэрхийлэх нь зөв. Дэгийн хуулиар бол манай Байнгын хороонд хамаарах асуудалд экспертээр орж ирж хамтран ажилласанд талархал илэрхийлье. Ажлын хэсгийг

Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуу ахалсан байгаа. Ажлын хэсгийн дарга Лодойсамбуу дарга та саналын төслөө танилцуулахыг урьж байна.

**Ч.Лодойсамбуу:** Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн болон Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр баталсан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоолд Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг, Ерөнхийлөгч 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсныг Улсын Их Хурал 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хүлээн авсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 90.8-д Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсан бол хууль, тогтоолын төслийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь хүчингүй болгох, шаардлагатай гэж үзвэл зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, тогтоолын төслийг хэлэлцэн баталж болно. 90.9-д Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсантай холбогдуулан хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах бол тухайн шийдвэрийн төслийг холбогдох Байнгын хороо боловсруулж, нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд уг төслийн талаар Засгийн газар холбогдох бусад байгууллагаас санал авахыг шаардахгүй гэж тус тус заасан.

Хэдийгээр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу Төсвийн байнгын хорооноос зохих нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг нэгдсэн хуралдаанд оруулахаар заасан боловч Монгол Улсын төсвийг төлөвлөх, боловсруулах, өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлах нь тусгайлсан зохицуулалттай цаглавар хугацаатай асуудал байдаг. Тухайлбал Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн хоёр дахь хэсгийн 2-т улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх гэсэн үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан.

Улсын Их Хурлаас төрийн эрх мэдлийн хяналт тэнцлийг хангах, Монгол Улсын 2025 оны төсвийг 2025 оны төсвийн жил эхлэхээс өмнө хэлэлцэн батлах зайлшгүй шаардлага бий болсон. Энэ шаардлагын хүрээнд Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн болон Хууль зүйн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоолд бүхэлд нь тавьсан хоригийг Монгол Улсын Их Хурал хүлээн авсантай холбогдуулан хууль, тогтоолыг хэлэлцэх асуудлаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуу миний бие ахлан, Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа, Ганмаа, Нарантуяа-Нара, Сайнзориг, Сандаг-Очир, Тэмүүжин, Уянгахишиг, Хэрлэн нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд ажлын хэсэг 2 удаа хуралдан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан хуралдааны дэгээр зохицуулаагүй асуудлыг хэлэлцэх журмыг баримтлан хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзэж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоолд бүхэлд нь тавьсан хоригийг Улсын Их Хурал хүлээж авсантай холбогдуулан хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх дэгийн тухай хуулийн төслийг боловсруулан танилцуулж байна.

Хуулийн төсөлд тусгагдсан гол зохицуулалт: 1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоолд бүхэлд нь тавьсан хоригийг Улсын Их Хурал хүлээж авсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 90 дүгээр зүйлийн 90.8, 90.9 дэх хэсэгт заасан хуулийн төслийг хэлэлцэн батлахтай холбоотой харилцааг зохицуулна.

2.Энэ хуулиар нарийвчлан зохицуулснаас бусад асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар зохицуулна.

3.Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсантай холбогдуулан Засгийн газрын боловсруулсан санал, тооцооллыг үндэслэн төслийг Төсвийн байнгын хороо нь нэгдсэн хуралдаанд оруулна.

4.Засгийн газар энэ хуулийн 2.1-д заасан санал тооцооллыг Төсвийн байнгын хорооноос тогтоосон хугацаанд ирүүлнэ.

5.Төсвийн байнгын хорооны хэлэлцэж, олонхын дэмжлэг авсан төслийг Улсын Их Хурал дараах 3 үе шаттайгаар хэлэлцэн батална.

6.Хууль, тогтоолын төслийг хэлэлцэхдээ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.14, 39.30-д заасан хугацааг баримтлахгүй буюу зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг ажлын 2-оос доошгүй өдрийн өмнө бичгээр урьдчилан ирүүлсэн байх шаардлагыг баримтлахгүй.

7.Энэ хууль нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсантай холбогдуулан хуульд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг эцэслэн баталснаар хүчингүй болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоолд бүхэлд нь тавьсан хоригийг Улсын Их Хурал хүлээж авсантай холбогдуулан хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх Дэгийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Баярбаатар:** Лодойсамбуу гишүүнд баярлалаа. Ажлын хэсгээс асуух асуулттай гишүүд нэрсээ өгье. Алдаржавхлан гишүүнээр тасаллаа. Алдаржавхлан гишүүн. Соронзонболд гишүүн асуулт асуух юм уу?

**Ж.Алдаржавхлан:** Би ганцаараа асууя. 2-хон асуулт байгаа юм. 1 дүгээрт энэ хуулийг заавал тусад нь ингэж хууль хийх шаардлага байсан уу? Одоо байгаа Дэгийн хууль дээрээ зүйл, заалт болгож, ер нь цаашдаа ирээдүйд хориг бүхэлд нь хүлээж авбал ийм харилцаагаар зохицуулна гэж хийж болоогүй юм уу 1 дүгээрт нь?

2-т нь нөгөө нэгэнт та хэд дэгийн асуудал ярьж байгаа юм чинь хамтад нь Төсвийн тухай хууль дээрээ орон нутгийн төсвийгөө хойшлуулах тэр зүйл, заалтаа хамтад нь боловсруулж болоогүй юу? Тэр нь 12 сарын 05-ны өдөр баталсан байх

ёстой гээд Төсвийн тухай хууль дээр байгаа шүү дээ орон нутгийн төсвийг чинь. Энэ юугаар бол хойшлох нь тодорхой болчхоод байна шүү дээ. Тэгээд тэрийг ерөөсөө ямар нэгэн байдлаар хуулийг хуулиар л хойшлуулахгүй бол Их Хурлын тогтоол дээр болохгүй байх гэж би бодоод байгаа юм. Тийм учраас энэ нэгэнт дэг боловсруулсан юм чинь тэр ажлын хэсгийнхээ хүрээнд яриад энийг бас нэг ганц хуудас ч юм уу зүйл хийж болоогүй юм уу л гэсэн ийм 2 асуулт байна.

**Б.Баярбаатар:** Лодойсамбуу гишүүн хариулчих, Лодойсамбуу гишүүний микрофон.

**Ч.Лодойсамбуу:** Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя. Энэ манай энэ байгуулагдсан ажлын хэсэг бол ерөөсөө яг одоо энэ хориг тавьсантай холбоотой хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг л асуудлыг хариуцаад, энийг яаралтай зохицуулъя гэдэг л ийм зорилготой ажлын хэсэг нэгд.

Хоёрт гэх юм яагаад ер нь тусдаа хууль байгаагүй юм бэ гэхээр Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар зохицуулна гээд заачихсан. Тэгэхээр заавал нэг хууль гаргаж байж бид нар энийг хэлэлцэхгүй бол болохгүй нөхцөл байдал үүсээд байгаа. Ер нь энэ Дэгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийснийх, юу энийг дэгийг ярьж байгаагийнх нэгмөсөн Дэгийн хуульдаа өөрчлөлт оруулаад бусад асуудлыг нь бүгдийг нь ингээд явъя гэдэг ийм санал бас ажлын хэсэг дээр гарсан. Ер нь энэ 1 удаагийн дэг гэхээсээ илүүтэй дэгтэй холбоотой олон асуудал ер нь гарч байгаа учраас нэг бүрчлэн ингээд, ингээд Дэгийн хуульдаа оруулъя. Ер нь цаашид ингээд Ерөнхийлөгч хориг тавих нөхцөл үүсэхийг, үүсэх юм байна гэдгийг ойлгож авсан.

Тийм учраас нэг удаагийн гэхээсээ илүүтэй энийгээ Дэгийн хуульдаа оруулаад явъя гэдэг ийм санал ажлын хэсэг дээр гарсан. Тэгээд ажлын хэсэг дээр олонхоороо ярьж байгаад юу гэсэн бэ гэхээр анхдугаар энэ чуулган эхэлснээс хойш энэ шинээр баталсан дэгээ ямар ч байсан нэг удаа явуулаад, энэ олон саналууд байгаа учраас тэд нарыг нэгтгээд дараа нь нэг мөсөн Дэгийн хуульдаа өөрчлөлт оруулаад явах нь зүйтэй. Яг энэ цаг нь тулчихсан байгаа энэ төсөв батлах шаардлагатай энэ цаг нь тулчихсан байгаа үед яг нэг удаагийн энэ зохицуулалтаар явах хуулийн дагуу шийдээд явах нь зөв юм байна гэдгийг ажлын хэсэг шийдээд ингээд явсан байгаа.

**Б.Баярбаатар:** Алдаржавхлан гишүүн тодруулъя.

**Ж.Алдаржавхлан:** Энэ илүү зөв гарц, манай Тамгын газрынхан мэдэж байгаа байлгүй дээ олон жил Их Хуралд ажилласан улсууд энэ нь илүү зөв гарц юм байна гэж тооцсон юм байна тийм ээ, би бол тэгж ойлголоо. Гэхдээ нэмэлт, өөрчлөлт ч гэсэн адилхан хууль шүү дээ. Тийм учраас тэгж хийсэн бол маргааш ч гэсэн энэ хуульд хориг тавих асуудал нээлттэй гээд байгаа шүү дээ. Тэгвэл дахиад ийм хууль гаргах уу? Дахиад хориг тавьсан хуульд дахиад дэг боловсруулах ёстой юу? Тийм учраас би нэгэнт дэгдээ өөрчлөлт оруулаад явчихвал зүгээр байсан юм биш үү? Дахин, дахин мөрдөх ёстой байхгүй юу, энэ чинь нэг удаагийн шинжтэй хууль чинь ингээд дуусчих гээд байна шүү дээ. Тийм учраас энийгээ та хэд тооцож үзвэл, үзсэн юм уу даа л гэж би бодож байгаа.



2-т нь тэр төсвийн харилцааны асуудлыг бол заавал бид нар хөндөж гаргахгүй бол энийг мөн орон нутгаас сонгогдсон хүмүүс л ингээд ардаа бодоод яваад байгаа байхгүй юу. Тийм учраас энэ орон нутгийн төсвийн харилцааны асуудлыг Улсын Их Хурлын тогтоолын хуулиар яаж хойшлуулдаг юм бэ? Тэрийг бас манай.../минут дуусав/

**Б.Баярбаатар:** Лодойсамбуу гишүүн хариулъя.

**Ч.Лодойсамбуу:** Тийм яг Алдаржавхлан гишүүний асууж байгаа энэ дахиад Ерөнхийлөгч энэ дээр дахиад хориг тавивал яах вэ гэдэг асуудал бол манай ажлын хэсэг дээр яригдсан. Ер нь энэ дээр зарчмын 2 асуудал яригдсан. Бид нарын хуулийн төсөл дээр зохицуулалт нь яаж явж байгаа вэ гэхээр энэ хуулийг хүчин төгөлдөр болсны дараа бид нарын энэ өөрчлөлт оруулж байгаа энэ хүчин төгөлдөр болсны дараа энэ хууль өөрөө хүчингүй болж байгаа юм. Тэгэхээр ямар нэгэн хориг тавилаа гэж бодлоо, тавилаа гэж бодоход тэр хоригийг хэлэлцээд, дахиад хэлэлцэхэд энэ хуулиа ашиглана гэсэн үг. Энэ хууль нь хүчин төгөлдөр болсны дараа л энэ Дэгийн хууль нэг удаагийн хууль маань хүчин төгөлдөр биш болно.

Нөгөө зарчмын асуудал нь юу вэ гэхээр үндсэндээ Ерөнхийлөгч бол Их Хурлын үйл ажиллагаа, Их хурлын баталсан хуульд 2 удаа хориг тавих, Их Хурлын үйл ажиллагаанд, Их Хурлын хууль тогтоох, хууль батлах үйл ажиллагаанд ингэж хөндлөнгөөс шууд үндсэн онцгой эрхэд нь ийм халдах ийм боломжгүй.

**Б.Баярбаатар:** Соронзонболд гишүүн асуулт асууна.

**Л.Соронзонболд:** Эхний асуулт ер нь Алдаржавхлан гишүүнтэй их адилхан байсан. Тэгээд хариулт ерөнхийдөө авчихлаа гэж үзэж байна. Яагаад гэхээр уг нь бол яах вэ зүгээр энд яригдаж байгаа асуудал нь Дэгийн тухай хууль дээр байгаа л заалтууд байна шүү дээ. Тэрийг л бид нар дахиад яг энэ 25 оны төсөвтэй холбоотой оруулж ирээд байгаа юм уу асуулт байсан юм. Тэгээд түүн дээр бол ерөнхийдөө хариулт өгсөн учраас.

2 дугаар асуулт болохоор бол энэ хоригтой холбогдуулаад ерөнхийдөө төсвийн тухай саналыг болохоор бол Засгийн газраас оруулж ирээд, тэгээд Төсвийн байнгын хороогоор хэлэлцэх юм байна, хэлэлцэх гэж байгаа юм байна гэж ойлгож байгаа юм. Тэгэхээр нэгдүгээр хэлэлцүүлгийн үед 3.5 дээр энэ дээр болохоор энэ бусад Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны гишүүн, нам, эвслийн бүлэг саналаа гэж байгаа байхгүй юу. Тэгээд зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт гаргана гээд. Тэгэхээр санал дээр нь тодорхой хэмжээний хязгаарлалт байх ёстой байсан уу гэдэг асуулт байгаа юм. Хэрвээ төсвийн зүйл, заалтаар шинээр санал гаргаж ирвэл тэрийг зөвшөөрөх юм уу гэдэг асуулт байгаад байна. Энэ дээр асуулт асууя.

2 дугаарт нь болохоор бол энэ 3.11 дээр болохоор бол санал тус бүрээр илээр санал хураах гэдэг нь системээр санал хураахыг ярьж байна уу эсвэл арай өөр асуудал ярьж байна уу гэдэг ийм асуулт байна.

**Б.Баярбаатар:** Лодойсамбуу гишүүн хариулна.

**Ч.Лодойсамбуу:** 1 дүгээрт энэ илээр санал хураана гэдэг нь энэ бол нөгөө нэг Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар яг санал хураалтыг томъёолохдоо тодорхойлсон яг тэрүүгээрээ л явна. Ил санал хураалт гэж юуг хэлэх вэ гэдэг нь тэр хуулиараа зохицуулагдаж байгаа.

Хоёрт энэ гишүүдийн гаргах санал дээр ингээд хүрээ хязгаар, тааз ямар нэгэн юм тогтоохгүй юм уу гэж. Тэгэхээр энэ нөгөө нэг энэ хуулийн төсөл буюу энэ төсөвтэй холбоотой асуудлыг хэрхэн хэлэлцэх вэ гэдэг зохион байгуулалт дэгийг нь хариуцаж байгаа хууль. Тэгэхээр ямар нэг байдлаар төсөв боловсруулах тэр нь, боловсруулах ийм үйл явцыг бол үүгээр зохицуулахгүй гэдэг үүднээс ажлын хэсэг ингэж үлдээсэн байгаа. Ямар ч байсан гишүүд саналаа оруулах эрхтэй байна. Тэгээд тэр Төсвийн хууль болон бусад хуулиудаараа Дэгийн хуулиараа байгаа хуулиараа мөрдөөд ингээд явна гэсэн үг.

**Б.Баярбаатар:** Соронзонболд гишүүн тодруулъя.

**Л.Соронзонболд:** Тэгэхээр гишүүд хэрвээ чөлөөтэй саналаа тавих нь гэвэл энэ чинь нэлээн их олон санал гарч ирвэл яах вэ гэдэг асуудлыг бодолцох ёстой болов уу л гэж бодоод байна л даа. Түүн дээр ажлын хэсэг дараагийн юун дээр анхаарах ёстой байх л гэж бодоод байна. Тэгэхгүй бол хэтэрхий чөлөөтэй тавьж болохгүй гэж бодож байгаа.

**Б.Баярбаатар:** Лодойсамбуу гишүүн хариулъя.

**Ч.Лодойсамбуу:** Анх бид нар энэ ажлын хэсгийг энэ төслийг хэлэлцэж эхэлж байхдаа эхний төсөл дээр нь одоо мөрдөгдөж байгаа Дэгийн хуулийн 71.8 буюу нам, эвслийн бүлэг, гишүүн, Монгол Улсын Ерөнхийлөгч, төрийн аудитын төв байгууллага тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардал нэмэгдүүлж санал гаргасан бол гээд ингээд энэ хүрээ хязгаарыг оруулчихсан байж байгаад энийг хассан. Дээр нь одоо бид нарын өргөн барьж байгаа энэ хуулийн төсөл дээр 3.7.2 дээр байж байгаа бид нарын энэ ерөнхий тааз бол энэ хэлэлцэж байгаа төслийн зарлагын болон алдагдлын дүнг нэмэгдүүлэхгүй л гэдэг ийм ерөнхий тааз хүрээ тавьсан байгаа.

Түрүүн нөгөө Алдаржавхлан гишүүний асуултад би дутуу хариулчихсан байна лээ. Тэр юуг одоо орон нутгийн төсөв батлах энэ хуулийн хугацаа тулчихлаа гээд байгаа. Тэгэхээр энэ бол манай ажлын хэсгийн хамаарсан асуудлаас халиад явчхаж байгаа учраас энэ Их Хурал дээр өөрөө нээлттэй байгаа. Тэгээд яг энэ тодорхой асуудал үүсчихсэн учраас Их Хурал өөрөө зохион байгуулаад, дахиж ажлын хэсэг байгуулаад, энийг хэлэлцэх боломж бол байгаа гэсэн үг.

**Б.Баярбаатар:** Соронзонболд гишүүн тодруулна.

**Л.Соронзонболд:** Хэлсэн асуудал дээрээ зарчмын зөрүүтэй санал гаргая гэж бодоод байна л даа. Яагаад гэхээр ингээд Засгийн газраас энэ хоригтой холбоотойгоор санал оруулж ирж байгаа. Тэгэхэд гишүүд болохоор бол санал оруулахдаа шинээр нэмж нэмэлт зардлын зүйл, анги оруулахгүй байх ёстой шүү дээ. Тэгэхээр тэрийгээ бид нар тавьж өгөх ёстой гэж бодож байна. Тийм учраас энэ талаараа зарчмын зөрүүтэй санал гаргая гэж бодож байна.

**Б.Баярбаатар:** Зарчмын зөрүүтэй санал гарах нь бол нээлттэй. Асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Номинчимэг гишүүнээр тасаллаа. Алдаржавхлан гишүүн үг хэлнэ.

**Ж.Алдаржавхлан:** Байнгын хорооны дүгнэлтэд тэгвэл миний энэ нэг саналыг заавал тусгаж өгөөрэй гэж. Орон нутгийн төсвийн хугацаа тулчихсан байгаа учраас орон нутгийн төсвийн харилцааг зохицуулах талаар Улсын Их Хурал дээр ямар нэгэн тодорхой шийдвэр гаргаж өгөөч гэж хүсэж байгаа. 21 аймаг, 9 дүүрэг, 330 сумдад байгаа иргэдийн Хурлын Төлөөлөгчид чинь одоо төсвөө батлах гээд хүлээгээд сууж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ харилцааг зохицуулах ямарваа нэгэн эрх зүйн гаргалгааг гаргаж өгөхийг хүсэж байна гэж Хууль зүйн байнгын хороо хамтарсан Байнгын хорооны дүгнэлтэд оруулах саналтай байна.

**Б.Баярбаатар:** Цогтбаатар дарга Хууль зүйн байнгын хорооны дарга.

**Д.Цогтбаатар:** Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ тусгайлан хууль гаргах бол хуулийн нэг шийдэл мөн л дөө. Тэгэхдээ энэ дээр манайхан нэг юмыг бодно биз. Хууль тогтоомжийн тухай хууль гэж байгаа. Түүн дээр тодорхой процедур юмнууд, шалгуурууд тавигдчихсан байгаа. Өнөөдөр, гэхдээ энэ бол хуулиа яаж гаргах юм гэдэг бол Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал учраас энийгээ бид нар аваад хэлэлцээд явж болох байх. Зүгээр ажлын хэсэг энэ дээрээ та нар хариултаа бэлдэхгүй бол тэр хуулийг тойрч бид нар шууд ингээд бариад хууль оруулна гэдэг чинь өөрөө ахиад асуудал үүсгэж байгаа юм.

Тэгээд ингээд Их Хурал хуулиа батлаад явчихад энэ хуулиар бол шийдэж болно. Гэхдээ энэний дагуу нэг юм бид нар бодох ёстой. Их Хурлын тогтоолд, дараа нь энийг дагаж гарах тогтоол байх уу яах вэ энэ дээр бол одоо ийм юм гарах тохиолдолд энийг шийдсэн байнгын шийдэл заавал гаргах ёстой. Түүнээс энэ бол одоо ингээд дуусаж. Тийм, энэ чинь нэг удаа. Харин тэгэхээр дараа нь ахиад ийм юм гарахад ерөөсөө зохицуулсан хууль байхгүй бол гарах болгонд дахиж хууль гаргаж болохгүй шүү дээ энэ чинь. Тийм учраас тэр өнцгөөсөө дахиад өөрөөр хэлбэл энэний дараа ажлын хэсэг гаргаад, энэ дээр бол энэ хуулийн зохицуулалтыг урт хугацааны, тогтмол зохицуулалтыг бол хийж өгөх ёстой.

Зүгээр нэг зүйлийг нэмээд хэлмээр байна. Манайхан ингээд хуулийг харахаараа яг 90 дүгээр зүйлээ хараад л 90-нхээ хүрээнд яриад байгаа байхгүй юу. Тэгтэл аливаа улс орны хууль гэдэг ерөнхий ойлголт чинь энийг зохицуулсан Улсын Их Хурлын тухай хууль, Үндсэн хууль гээд аягүй олон хууль эд нарынхаа уулзвар цэг дээр уг нь шийдэл олж байх ёстой. Тийм шийдэл өнөөдрийн Монгол Улсын хуульд байгаа шүү. Гэхдээ энийгээ өнөөдөр бас эргээд эрсдэл дагуулах нь байна гэж үзээд ийм хувилбараар орж ирж байгаа бол энэ бас эрх зүйн шийдлийн нэг нь мөн. Тэр утгаар нь бол би энийг ойлгож, хүлээж авч байна. Энийг ямар ч гэсэн протоколд тэмдэглэж үлдээе гэж бодож байгаа юм.

**Б.Баярбаатар:** Баярлалаа. Номинчимэг гишүүн.

**О.Номинчимэг:** Бид нар хамгийн гол нь нөгөө дэг нь ямар вэ яасан, энэний дараа яах вэ гэхээсээ илүү асуудлаа шийдэх нь аягүй чухал байгаа. Тэгээд асуудлаа бол ер нь хамгийн боломжит хурдан хугацаанд шийдэх нь чухал байгаа гэж харж байгаа. Тэгэхээр ерөнхийдөө энэ Дэгийн анхдагч хууль, нэг удаагийн шинжтэй анхдагч хуулийг зарчмын хувьд дэмжиж байна. Хурдхан шиг Засгийн

газраас саналыг нь авсан байдлаар, тэгээд зарлагын болон алдагдлын дүнг нэмэгдүүлэхгүй байх гэдэг зарчим дээр юм чинь зүгээр саяын ярианд гарсан тэр Засгийн газар бол яах вэ тооцооллоо өгөх юм байна. Гэхдээ Төсвийн байнгын хорооноос үүнийгээ танилцуулаад явна. Өмнөх, өмнөх жилүүдийн туршлагыг харж байхад бид нар энэ нөгөө бодлого гаргаж ирсэн төсөв дээр гишүүд өөрсдөө бие биетэйгээ барьцаад янз бүрийн нэмэгдэл зардал, төсөл, хөтөлбөр нэмдэг асуудлыг хязгаарлах хэрэгтэй. Тэгэхгүй бол хугацаандаа баригдаад 12 сарын 31-нээс өмнө гээд ийм, ийм шахалтад ороод, төсвөө задлах эрсдэлээс бол хамгаалах шаардлагатай гэж үзэж байна. Тэгэхээр тэр асуудал дээр Соронзонболд гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргаж байгааг нь би бол дэмжиж байна.

Ер нь Ерөнхийлөгчийн хориг бол өөрөө төсвийн үр ашигтай байдал, хэмнэлттэй байдал, зарлагыг бууруулах тал руу яваач гэсэн гол агуулга, концепц байсан. Тэгэхээр энэ концепцыг бид нар зөв байна, хориг нь зөв байна гэж хүлээж авсан юм бол тэр чиглэлийн хязгаарлалтуудыг нь ч гэсэн энэ зөвхөн нэг удаагийн шинжтэй энэ хууль дээрээ дэг дээрээ оруулах ёстой. Энэ бол дараа дараагийн хориг дээр хэрэглэгдэнэ гэсэн юм байхгүй. Сая Лодойсамбуу ажлын хэсгийн дарга хэлж байна. Энэ дахиад хориг тавьчих юм бол энийгээ хэрэглэнэ гээд үгүй. Энэ хуулийн үг, үсгийг харвал энэ ерөөсөө төсөв эцэслэн батлагдсанаар энэ хууль чинь хүчингүй болж байгаа гэж байгаа юм. Эцэслэн батлагдах, дараа нь хориг тавиад явах гэдэг чинь өөр процесс учраас энэ бол энэ төсөв батлагдах хүртэл үргэлжлэх ийм дэг байгаа.

Тэгэхээр энэ дээрээ яг дэгийг бид нар хурдхан хугацаанд ямар нэгэн хугацаанд шахагдаж янз бүрийн эрсдэл байдал үүсгэхгүйгээр явъя гэх юм бол ер нь тэр зардлуудаа танах зарчмаа бол ерөөсөө оруулчих хэрэгтэй гэж бодож байна. Тэгэхээр дэмжиж байна. Зүгээр миний хувьд бол бас нэг зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа. Төслийн 2.8 дээр төсвийн талаар төрийн аудитын байгууллага болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг гаргуулж болно гэхчхэн. Энэ төсөв бол угаасаа анх орж ирэхдээ энэ дүгнэлтүүд нь гарчихсан, Засгийн газар энэ дээрээ зарчмаа бариад нэг их шинэ юм оруулж ирэхгүй байх гэж бодож байна. Илүү зардлаа хэмнэсэн, үр ашигтай байх тал руугаа авсан юмнууд орж ирэх байх. Тэгэхээр энэ дээр бол бараг ийм шаардлага аудитын байгууллагын дүгнэлт бол бараг хэрэггүй шүү дээ. Цаг хугацаа ч байхгүй. Тэгэхээр ийм юмнаас болоод нэг цаг хугацаа алдсан, асуудлаа шийдэж чадахгүй, сунжирсан юм руу явуулчихгүйн тулд би бол 2.8 гэсэн энэ гаргуулж олно гэсэн асуудал дээр бараг хэрэгцээ шаардлага гарахгүй болов уу гэдэг үүднээс энэ зүйл, заалтыг хасах ийм зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа юм.

**Б.Баярбаатар:** Гишүүд санал хэлж дууслаа. Энэ ажлын хэсэг богинохон хугацаанд их бүтээмжтэй ажиллажээ. Төсөлтэй танилцлаа. Оролцоог бол нэлээн нэмэгдүүлсэн, боломжуудыг нэлээн нээж өгсөн ийм дэгийн санал оруулж ирсэн байна. Миний хувьд Ёс зүй, дэгийн байнгын хороонд хамаарах асуудлын хувьд бол бүрэн дэмжиж байна. Гишүүдийн хэлсэн саналтай бол санал нэг байгаа. Ер нь цаашдаа бид нар энийгээ бол энэ Дэгийн хуульдаа цаг хугацааны хувьд хэзээдээ байх юм гэдгийг нь нэгдсэн байдлаар ганцхан энэ асуудал гэлтгүйгээр өөр бидэнд доголдол үүсгэж байгаа, асуудал бий болгож байгаа ийм зүйл, заалтуудыг нэгдсэн байдлаар ажлын хэсэг байгуулж бол ирэх жил би энэ Дэгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болов уу гэж харж байгаа. Тэгэхдээ энэ саналуудаа бол бид нар одоогоос ер нь бол авч байгаа шүү. Байнгын хороон дээрээ бид нар аваад ийм, ийм асуудлууд байна гэдгийг нэгтгээд явна гэж үзэж байгаа.

Алдаржавхлан гишүүний ярьж байгаа санал өөрөө, асуудал өөрөө зөв. Тэгэхдээ энэ бол ажлын хэсэг төдийгүй манай 2 Байнгын хороонд өнөөдөр олгогдоогүй эрх байхгүй юу. Бид нар яг энэ хүрээндээ нөгөө хориг тавьсан хүрээндээ ямар дэгээр, ямар саналаар хэлэлцэх вэ гэдгээ гол болгож байгаа болохоос одоо таны ярьж байгаа зүйл бол Төсвийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болчхож байгаа юм. Ёстой жинхэнэ нөгөө Хууль тогтоомжийн хууль нөгөө өргөн мэдүүлэх үү, яаралтай юу гэдэг нэг ийм тусдаа ийм юугаар явчхаж байгаа учраас тэнд бол өнөөдөр яг манай хамтарсан Байнгын хорооны ч нөгөө хэлэлцэх асуудлын чиг үүрэг нь өөрөө биш болоод явчхаж байгаа.

Тэрнээс бол яг асуудал нь бол өөрөө зөв. Одоо ингээд 12 сарын 05-наас өмнө бол нэг ч орон нутгийн байгууллага төсвөө баталж чадахгүй болчихлоо, амжихааргүй болчихлоо. Бид нар өөрсдөө бараг 5-ндаа амжих уу, үгүй юу гэдэг асуудал өөрөө явчхаж байгаа учраас, амжихааргүй болчхож байгаа учраас энийг бол дараа нь эрх зүйн зохицуулалтыг нь заавал гаргах нь зөв байх. Маргааш Даргын дэргэдэх зөвлөл дээр энэ талаар харин би ярьж санал оруулъя гэсэн бодолтой байна.

Зарчмын зөрүүтэй санал. Номинчимэг гишүүн Төслийн 2.8-д заасан төрийн, төслийн талаарх төрийн аудитын байгууллага болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг гаргуулж болно гэсэн заалтыг хасах саналыг оруулж байна. Номинчимэг гишүүний саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 15 хувиар санал дэмжигдсэнгүй. Санал хураалтаар асуудал шийдэгдсэн учраас энийгээ орхиё.

Дараагийн асуудал энэ 3.4, 3.5 дээр Соронзонболд гишүүнээс, 3.4, 3.5 гэхчхэн байна. Тийм. Засгийн газраас оруулж ирсэн санал дээр шинээр нэмж зардлын зүйл, төсөв нэмэхийг хязгаарлах шаардлагатай. 3.7.3.Төсөлд зардлын зүйл шинээр нэмэхгүй байх гэсэн ийм шинэ заалт оруулъя гэсэн зарчмын зөрүүтэй санал байна. Санал гаргаж байгаа юм байна. Та өөрөө тайлбар хэлэх үү энэ дээрээ? Хэлчихсэн үү, дахиж хэлэх үү? Тэгвэл энэ саналыг дахиад унших уу би. Засгийн газраас оруулж ирсэн санал дээр шинээр нэмж зардлын зүйл, төсөв нэмэхийг хязгаарлах шаардлагатай шалтгаан нь. 3.7.3.Төсөлд зардлын зүйл шинээр нэмэхгүй байх гэсэн заалтыг нэмье гэсэн саналын томъёоллоор санал хураа. Санал хураалт. 25 хувиар санал дэмжигдсэнгүй. Асуулт асууж, санал хэлж, саналын зөрүүтэй саналаар санал хурааж дууслаа. Зарчмын зөрүүтэй саналаар.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоолд бүхэлд нь тавьсан хоригийг Улсын Их Хурал хүлээж авсантай холбогдуулан хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх Дэгийн тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оруулж, хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 70 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоолд бүхэлд нь тавьсан хоригийг Монгол Улсын Их Хурал хүлээн авсантай холбогдуулан хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх дэгийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх

хэсэгт заасны дагуу Ёс зүй, дэгийн байнгын хороо болон Хууль зүйн байнгын хорооны хамтарсан санал, дүгнэлтийг Ёс зүй, дэгийн байнгын хорооны гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Чулуунбилэгийн Лодойсамбуу танилцуулна.

14.35 цаг

Хэлэлцэх асуудал дууслаа. Хуралдаанд ирсэн гишүүддээ баярлалаа. Хурал өндөрлөснийг мэдэгдье.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

*Д.УЯНГА*